

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

**“САН РЕМИКОН” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ ХХК Б.ЦОГТБААТАР**



**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 21-Р ХОРООНЫ НУТАГТ ОРШИХ
“САН РЕМИКОН” ХХК-ИЙН БЕТОН ЗУУРМАГИЙН ҮЙЛДВЭРИЙН 2025 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 6534759

ХЯНАСАН:

ҮЙЛДВЭРИЙН ДАРГА

БОЛОВСРУУЛСАН:

БАЙГАЛЬ ОРЧНЫ ИНЖЕНЕР

НЭР

НЭР

2025 ОН

ГАРЧИГ

1. ҮЙЛДВЭРИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	2
2. ҮЙЛДВЭРИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОТ.....	5
3. ҮЙЛДВЭРИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ.....	7
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ.....	11
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	12
6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	16
7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	17
8. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	17
9. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ.....	19
10. ОРЧНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	20
11. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	21
12. ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	22
13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРДЛЫН УРЬДЧИЛСАН ТООЦОО.....	23

1. ҮЙЛДВЭРИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Сан Ремикон” ХХК-ийн бетон зуурмагийн үйлдвэр нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлан үйл ажиллагаа явуулж байна.

Үйлдвэр нь М100–М500 маркын баталгаат чанартай бетон зуурмаг үйлдвэрлэж, тогтмол зах зээлд нийлүүлдэг. Бүтээгдэхүүн нь MNS EN 206:2017 “Бетон Шаардлага, гүйцэтгэл, үйлдвэрлэл, тохирол”, MNS 1185:1998 “Бетон зуурмаг Техникийн шаардлага” стандартуудын шаардлагад бүрэн нийцдэг.

Үйлдвэрийн үйлдвэрлэлийн хүчин чадал нь цагт 150 м³, хоногт 1500 м³ бетон зуурмаг бөгөөд одоогоор захиалгын дагуу өдөрт 600 м³ бетон зуурмаг үйлдвэрлэж байна. Үйл ажиллагааг нийт 10 ажилтны бүрэлдэхүүнтэйгээр гүйцэтгэж байна.

Бетон зуурмагийн найрлагад хэрэглэгдэх дүүргэгчийн ширхэгийн бүрэлдэхүүн, цементийн анги, идэвхжил, нэмэлтийн төрөл, ус, цемент, дүүргэгчийн зохистой харьцаа зэрэг олон хүчин зүйлийг нарийвчлан харгалзан үзэж үйлдвэрлэл явуулдаг. Мөн дүүргэгч материал болон барьцалдуулагчийн физик, механик шинж чанарыг үйлдвэрлэлд ашиглахаас өмнө дотоодын лабораторид сорилт, туршилтаар тогтоон шинжилдэг.




Зураг 1. Үйлдвэрийн байршил

1.1 Үйлдвэрийн тоног төхөөрөмж: Үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжийн хувьд цагт 150м³ етон зуурмаг үйлдвэрлэх хүчин чадалтай SJ-2500 загварын холигч тогоо, тус бүр нь 25 м³ –ийн багтаамжтай анхдагч бункер цемент хадгалах 300 тонны

багтаамжтай 1 ширхэг, 100 тонны багтаамжтай 2 ширхэг силос, 10 тонны багтаамжтай нэмэлтийн сав, 15 миксер авто машин зэрэг үндсэн тоног төхөөрөмжөөс бүрдсэн.

Схем1. Үйлдвэрлэлийн ажлын схем



1.2 Үйлдвэрийн түүхий эд Бетон зуурмагийн үйлдвэр нь үйлдвэрлэлд ашиглах түүхий эд, материалыг дотоодын компаниудтай гэрээ байгуулж татан авдаг. Үүнд:

- **Цемент** – Дотоодын цемент үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдээс ханган авдаг.
- **Дүүргэгч материал** – Улаанбаатар хотын тусгай зөвшөөрөлтэй элс, дайрганы карьеруудаас нийлүүлдэг.

- **Химийн нэмэлт** – “Адмикс Эко Плас” ХХК-ийн РС-F, РС-C төрлийн нэмэлтийг хэрэглэдэг.
- Үйлдвэрт ашиглах усны эх үүсвэр болон ус ашиглалтын зөвшөөрлийг Нийслэлийн Байгаль орчны газраас авч, баталгаажуулсны үндсэн дээр үйлдвэрт ашиглаж байна.

Бид төслийн хүрээнд хэрэгжүүлж буй бүхий л үйл ажиллагаандаа байгаль орчныг хамгаалах чиглэлээр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, стандартуудыг чанд мөрдөн ажилладаг. Үйл ажиллагааны явцад үүсч болох сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, байгаль орчныг хамгаалах зорилтыг тогтмол баримтлан хэрэгжүүлж байна.

Бетон зуурмагийн үйлдвэр нь дараах зорилтыг дэвшүүлэн ажилладаг. Үүнд:

- Байгалийн нөөц баялгийг урт хугацаанд тогтвортой, үр ашигтай, зохистой ашиглах, нөхөн сэргээх төрийн бодлогыг хэрэгжүүлэх; эрх бүхий байгууллагуудаас баталсан байгаль орчны стандарт, хэм хэмжээ, дүрэм журмыг чанд сахин биелүүлэх, дотоодын болон хөндлөнгийн байгаль орчны хяналтыг тогтмол хэрэгжүүлэх.
- Олон улсын байгаль орчны байгууллагууд болон байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи бүхий туршлагатай компаниудтай хамтран ажиллаж, олон улсын байгаль орчны стандартуудыг өөрийн үйлдвэрлэл, үйл ажиллагаанд нэвтрүүлэх.
- Нөхөн сэргээгдэхгүй байгалийн нөөц баялгийг ариг гамтай ашиглах, хаягдалгүй технологи болон дахин боловсруулах аргачлалыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх.
- Байгалийн нөөцийн ашиглалтын үр ашгийг өндөр түвшинд байлгах зорилгоор тогтмол судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэж, орчин үеийн үр ашигтай техник, технологийг тууштай нэвтрүүлэх.
- Байгаль орчны талаар баримталж буй компанийн бодлого, зарчмыг хамтран ажиллаж буй түнш байгууллага, гэрээт гүйцэтгэгчдэд таниулж, байгаль орчны чиглэлээр тавих шаардлагыг өндөржүүлэх замаар тэдний хариуцлагыг нэмэгдүүлэх.



Зураг 2. Үйлдвэрийн харагдах байдал

2. ҮЙЛДВЭРИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОТ

2.1 Хөрсөн бүрхэвч

Хөрс газарзүйн мужлалтаар Улаанбаатар хотын хөрс-био уур амьсгалын Хангайн их мужийн Хэнтийн өмнөх тойрогт багтах бөгөөд Туул голын өргөн хөндий, Хэнтийн нурууны салбар уулын энгэр хажуугаар ихэвчлэн хар хүрэн хөрс зонхилно.

Улаанбаатар хотын нутаг дэвсгэр нь хөрс-газар зүйн мужлалтаар, хөрсний өндрийн бүсшилийн хэвшинж бүхий Хэнтий орчмын 52, 43-р тойргуудад хамаарагдана. Дүүргийн нутаг дэвсгэрийн хойд хэсгээр ойн хөрс, уулын хар шороон, ам хөндийгөөр нуга-намгархаг хөрстэй байхад урд хэсгээр уулын хар хүрэн хөрс голчлон тархана. Туул, Сэлбэ, Дунд, Улиастай зэрэг том жижиг голуудын хөндийгөөр аллювийн хөрстэй.

Үйлдвэрийн талбайд хийсэн хөрсний шинжилгээний үр дүнгээс үзэхэд хүнд металлын бохирдол илрээгүй бөгөөд бохирдуулагч бодисуудын агууламж хүлцэх хэмжээнд байсан нь тогтоогдсон. Никель болон цайрын агууламж хэвийн түвшинд байгаа бол зэсийн агууламж харьцангуй өндөр буюу 5.31 мг/кг хэмжигджээ. Бусад үзүүлэлтүүдийн хувьд хөрсөн бүрхэвчийн төлөв байдал хэвийн, бохирдолгүй байна.

2.2 Ургамлан бүрхэвч

Улаанбаатар хот нь Хэнтийн уулын тайгын тойрог, Монгол дагуурын уулын ойт хээрийн тойрог гэсэн хоёр тойргийн уулзвар нутагт хамаарна. Хотгор гүдгэрийн мужлалаар Улаанбаатар хотыг тойрон хүрээлэх Хэнтийн нурууны баруун захын салбар дундаж, нам уулс, тэдгээрийг тусгаарлан орших голуудын хөндийгөөс бүрдэнэ. Эдгээр уулс нь Сибирийн геоморфологийн их мужийн Хэнтийн мужид багтах хавтгайдуу оройтой, эрс хажуу бүхий дундаж уулсын системд хамаардаг.

Үйлдвэрийн эзэмшил талбайн ургамалжилтын хувьд дараах ургамлын зүйлүүд зонхилж байна:

Хүснэгт 1 Талбайн ургамалжилт

№	Ургамлын латин нэр	Монгол нэр	Бүрхэцийн хувь (%)
1	Artemisia frigida	Агь шарилж	23%
2	Stipa sp.	Хялгана	15%
3	Artemisia sp.	Шарилж	11%
4	Achnatherum splendens	Дэрс	12%
5	Artemisia sp.	Шарилж	4%
6	Potentilla bifurca	Имт гичгэнэ	10%

2.3 Амьтны аймаг

Улаанбаатар хот амьтны аймгийн газарзүйн мужлалаар умардын их мужийн хөвч тайгын дэд мужийн Хэнтийн тойрогт багтана. Судлаачдын тооцоолсноор уг нутагт 50 орчим зүйл хөхтөн амьтадтай. Их хотын чимээ шуугиан, хүн, авто хөсөг, бэлчээр тэжээлийн хүрэлцээ зэргээс шалтгаалан амьтад нэг газар байнга оршин амьдардаггүй улирлын чанартай нүүдэллэн шилждэг онцлогтой.

Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн төв хэсэгт амьтны аймгийн төрөл зүйл аль хэдийн байгалийн нутагшил, шилжих хөдөлгөөн нь бүрэн алдагдаж зөвхөн хот сууринд амьдардаг цөөн тооны хөхтөн, шувуу зэрэг амьтад байгаа болно. Энэ орчимд шувуудын дотроос тоо толгойн хувьд оронгийн (*P.domesticus*) ба хээрийн (*P.montanus*) бор шувуу, хөхвөр тагтаа (*C.livia*), Сохор элээ (*Milvus migrans*), Шаазгай (*Pica pica*), Улаан хошуут (*Pyrrhocorax pyrrhocorax*), Хар хэрээ (*Corvus corone*), Хон хэрээ (*Corvus corax*) арай олон үзэгддэг байна. Хөхтний дотроос дагуур зурам, хэргэлзий оготно, үлийн цагаан оготно, гэрийн хулгана нутагшиж байна. Шавьжийн ангиас төрөл бүрийн цохын овог тааралдана

2.4 Төслийн талбайн хамгийн ойр орших Тусгай хамгаалалттай газар нутаг

Богд хан уулыг 1957 оны 03-р сарын 13ны Ардын их хурлын Тэргүүлэгчдийн 31-р тогтоол, 1974 онд Ардын их хурлын Тэргүүлэгчдийн 248-р зарлиг, 1995 оны УИХ-ын 26-р тогтоолоор хамгаалалтанд авсан.

Богдхан уул нь манай орны төдийгүй дэлхийн ууган дархан газрын тоонд зүй ёсоор орно. Монголчуудын эрт дээр үеэс энэ уулыг дархан цаазтай болгон хамгаалж байсны дотор XII-XIII үед Монголын Хэрэйд аймгийн тэргүүн Ван хаан дархлан тахиж Хан уул хэмээн нэрлэсэн гэдэг. Богд уулыг 1778 онд албан ёсоор дархалсан. Улсын их хурлын 1995 оны 26 дугаар тогтоолоор “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай” хуулинд нийцүүлэн дархан цаазат газрын ангиллаар баталгаажуулсан байна.

Дархан цаазат уулын хамгийн өндөр оргил нь далайн түвшинээс дээш 2268.0 м өндөрт өргөгдсөн Цэцээгүн юм. Богдхан ууланд эмчилгээний ач холбогдолтой хэд хэдэн рашаан булгууд бий. Зарим газар хушин ой, баруун урд ба өмнөд хэсгээр гацууран ой, баруун урд хэсгээр нарсан ой, хойд ба зүүн өмнөд хэсгээр нь шинэсэн ой зонхилон тархдаг нь тус уулын хэсэг бүрт экологийн нөхцөл өөр байдгийг гэрчилнэ. Богдхан ууланд 70 овгийн 256 төрлийн 588 зүйлийн дээд ургамал ургадаг. Ургамлын аймаг нь экологийн 18 бүлэгт хамаарах бөгөөд эдгээрээс уулын тайгын экологийн бүлгүүд 80 хувийг, хээрийн ургамлууд 72 хувийг эзэлдэг. Хэнтийн тайгын голлох элемент болон олон зүйлийн хөхтөн амьтны тархалтын урд хил нь Богдхан уул болно. Богдхан ууланд монгол орны 6 баг, 17 овог, 36 төрөл, 54 зүйлд хамаарах хөхтөн амьтан нутагладаг байна. 174 овог, 270 гаруй төрөлд хамаарах 1660 зүйл шавж, 259 зүйлийн мезофаун, 93 микрофаун, 14 баг, 36 овогт багтах 194 зүйл шувуу бүртгэгдсэн.

ТХГН-ийн байгалийн болон түүх соёлын дурсгалт газар

Богдхан уулын ам хөндий хажуу хормойгоор бичигт, зурагт хад цохионууд, хиргисүүр, хөшөө, булш зэрэг түүхийн дурсгалт зүйл олонтой. Цэцээ гүний орой дээр сайд Юндэндоржид зориулсан сүмийн туурь байдаг. Их, бага тэнгэрийн амны хооронд орших хадан цохион дээр согоо, гуа марал, бортого малгай, ээтэн гутал, нөмгөн дээлтэй бүсгүй хүний дүрс, бугын сүг зураг зэргийн хамт уйгаржин бичгээр сийлсэн “Мөнх тэнгэрийн хүчин суу залийн ивээлд” гэсэн бичгийн дурсгал байдаг.

2.5 НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ

Хан-Уул дүүрэг нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын баруун урд хэсэгт дархан цаазат Богд хан уулын ар хормой, Туул голын савд 50.3 мянган га нутаг дэвсгэрийг эзэлж оршдог. Тус дүүрэг нь 2024 оны байдлаар 21 хороо, 3557 мянган өрхийн 13.117 мянган хүн амтай.

Нийслэлийн Хан-Уул дүүргийн газрын нэгдмэл сан нийт 50352 га байна. Үүнээс: хөдөө аж ахуйн газар 22451.12 га (44.6%), хот тосгон бусад суурин газар 7088.18 га (14.1%), зам шугам сүлжээний газар 2960.3 га (5.9%), ойн сан бүхий газар 2098.0 га (4.2%), усан сан бүхий газар 975.0 га (1.9%), улсын тусгай хэрэгцээний газар 14779.0 га (29.3%) тус тус эзэлж байна.

3. ҮЙЛДВЭРИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Үйлдвэрийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг 2024 онд батлагдсан БОННУ тодотголоор дараах байдлаар тодорхойлсон.

Хүснэгт 2. Болзошгүй сөрөг нөлөөллийн магадлан жагсаалт

№	Байгаль орчны үзүүлэлт	Хэлбэр			Хугацаа				Эрчим		
		Нөлөөлөлтэй эсэх, +,-, 0	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт											
1	Газрын доорхи урсацын өөрчлөлт	0									
2	Газрын доорхи усны чанарт өөрчлөлт	-		-		-					-
3	Гадаргын усны өөрчлөлт	0									
4	Агаарын чанарын өөрчлөлт	-	-			-				-	
5	Ургамлын бүтцийн өөрчлөлт	-	-			-					-
6	Хөрсний элэгдэл, эвдрэл	-	-				-			-	
7	Геологийн тогтцын өөрчлөлт	0									
8	Зэрлэг амьтдын орон зай	0									

9	Уур амьсгалын бичил өөрчлөлт	0									
Байгалийн нөөц ашиглалт											
10	Гадаргын нөөц баялаг	-				-					-
11	Бэлчээрийн байдал	0									
12	Эрдэс түүхий эдийн нөөц	0									
13	Эрчим хүчний нөөц	-				-					-
Байгаль орчны өөрчлөлт											
14	Ундны усны чанар, хэмжээ	0									
15	Урсгал усны хэрэгцээ	0									
16	Агаарын бохирдол	-	-			-				-	
17	Хөрсний эвдрэл бохирдол	-	-				-				-
Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор											
18	Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх	0									
19	Ландшафтийн хэлбэр, өнгө өөрчлөгдөх	0									
20	Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх	0									
21	Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх	0									
22	Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх	0									
Эдийн засаг, нийгмийн асуудал											
23	Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	+	+			+				+	
24	Орон нутгийн орлого нэмэгдэх	+	+			+				+	
25	Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	+	+				+			+	
26	Ажлын байр нэмэгдэх	+	+				+			+	
27	Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	+	+				+			+	
28	Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх	-		-						-	
Бусад нөлөөлөл											
29	Хүн амын дунд халдварт өвчин тархах	-		-		-					-
30	Малын халдварт өвчин тархах	0									
31	Байгалийн онц аюултай үзэгдэл /үер, шороон шуурга, цасан шуурга, аянга/	0									
Нөлөөлөлгүй		16									
Сөрөг нөлөөтэй		-10	-7	-3	-1	-7	-2			-4	-6
Эерэг нөлөөтэй		+5	+5			+2	+5			+1	+4

Хүснэгт 3. Болзошгүй сөрөг нөлөөллийн дүгнэлт

Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлтийн магадлагаа	Газрын доорх усны чанарын өөрчлөлт: Төслийн үйл ажиллагаанд үзүүлэх сөрөг нөлөөллийн нэг хэсэг буюу бидний хамгийн гол анхаарах ёстой зүйл бол гүний усны ашиглалт бөгөөд энэ нь гүний усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөлөл бөгөөд мөн гүний усны чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл байж болох магадлалтай. Нэг үгээр хэлбэл тухайн төсөлд ашиглаж буй усны насосны гүний уснаас татан авч буй шугам төмөр хойлоо байх бөгөөд энэхүү хоолойн зэврэлт нь гүний усны чанарт сөрөг нөлөөлөл үзүүлэх магадлалтай гэж дүгнэхэд хүргэсэн болно.
	Агаарын чанар: Бетон зуурмагийн үйлдвэр нь агаар орчныг бохирдуулах 2 үндсэн бохирдуулагч эх үүсвэр байх ба тээвэрлэлтийн үеийн болон үйлдвэрийн агаар бохирдуулагч эх үүсвэр гэж 2 ангилна. Тээвэрлэлтийн үеийн агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл хэлбэр нь шороон зам ашиглах явцад гарах тоос болон ачиж тээвэрлэж буй авто машины яндангаас гарах утаа зэрэг болно. Үйлдвэрийн агаар бохирдуулагч эх үүсвэр нь бетон зуурмагт ашиглах хайрга дайрганы овоолгоос хийсэх тоосжилт болон бетон зуурах үеийн холих үед гарах тоосжилт зэрэг болно. Мөн тухайн хайрга дайргыг ачиж буулгах үед гарах тоосжилт зэрэг нь агаар орчинг бохирдуулах гол эх үүсвэр болох магадлалтай гэж үзэж байна.
	Ургамлан бүрхэвч болон хөрсөн бүрхэвч-д үзүүлэх сөрөг нөлөөлөл: Төслийн үйл ажиллагаа явуулж буй одоогийн талбай нь хөрсөн бүрхэвч хэсэг үйл ажиллагаа явуулж буй талбайн хэмжээнд хүчтэй сөрөг нөлөөлөлд өртөн талхлагдсан бөгөөд тухайн орчинд ургамлан бүрхэвчийн тархалтгүй болсон төдийгүй тухайн төсөл хэрэгжүүлэгчийн өөрсдийн тарьж ургуулсан нарс болон хайлаас гэх мэт модлог ургамал цөөн тоогоор ургах ба мөн хог ургамал буюу шарилж гэх мэт талахлагдалын эндекатор ургамал ургах бөгөөд төслийн үйл ажиллагааны зүгээс ургамлан бүрхэвчид үзүүлэх сөрөг

Хүснэгт 4. Хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл

№	Нөлөөлөл	Магадлал	Нөлөөллийн эрчим				
			Нөлөөлөл үгүй	Бага	Дунд	Их	Онц уршигтай
1	Барилгын суурийн талбайн хэсэгт өнгөн хөрс, ялзмагт давхаргын хамт хуулагдах	Зайлшгүй	0				
2	Хөрсөн бүрхэвчийн өнгөн хэсэг дефлюцид өртөх	Зайлшгүй	0				

3	Хөрсний биоценоз дахь шавж, бичил биетний үржил, тархалтанд нөлөөлөх	Боломжтой	0				
4	Хог хаягдлын замбараагүй байдлаас үүдэн хөрсөн бүрхэвч химийн бодис, шингэн хог хаягдлаар бохирдох	Боломжтой		*			
5	Хөрсөн бүрхэвчийг хүчтэй доройтуулснаар ургамлан нөмрөг устаж үгүй болон бэлчээрийн байдалд нөлөөлөх	Магадлалтай	Хөрсний доройтолд аль хэдийн өртөж хөрс ургамал ургах нөхцөлгүй болсон бөгөөд сул шороон гадаргатай болсон. Харин энэхүү нөлөөлөл цааш үргэлжлэхгүй бөгөөд тоосжилтыг бууруулах арга хэмжээ авах шаардлагатай				
6	Ажиллагсадын хөл хөдөлгөөн ихсэж төлөвлөсөн зам маршрутаас өөр жим, харгуйг үүсгэх	Магадлалтай	0	Төслийн үйл ажиллагаа явуулдаг тогтсон маршруттай болсон байна энэ нөлөөлөл цааш үргэлжлэхгүй			
7	Хөрсөн бүрхэвчийн бохирдол тоосжилтоос үүдэлтэй үүдэж ургамал ургах шим тэжээлийн бодсын хэмжээ багасч мөн ялзмаг багасах	Магадлалтай			*		

Хөрс, ургамлан бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийн хэлбэрүүд:

1. Үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглах хайрга дайрганы овоолго ба түүнээс ялгарах тоос тоосонцор
2. Үйлвэрт ачигдан ирэх хайрга, дайрга болон цементийг зөөвөрлөх үеийн тээврээс үүсэх тоосжилт болон тоос, утаа, тортог
3. Үйлдвэрийн үйл ажиллагаанаас гарах бэлэн бүтээгдхүүнийг зөөвөрлөх явцад машин техник хэрэгслээс гарах тоосжилт
4. Авто миксерийн цемент агуулах савыг угаасан усыг зориулалтын бус газар асгаснаас хөрс бохирдож ургамал ургах орчинд нөлөөлөл үзүүлэх нөхөн сэргээлт хийхэд бэрхшээлтэй болох
5. Үйлдвэрийн ажилчдын ахуйн хэрэглээнээс гарах хатуу, шингэн хаягдлаас хөрс, ургамлан бүрхэвч бохирдох магадлалтай

Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл

1. Үйлдвэрийн усан хангамж болон ахуйн хэрэглээний уснаас өөр зориулалтаар ус ашиглаж боломжит ус ашиглах байдлаас давуулан ашиглах
2. Төслийн талбайд одоогоор гүний худаг өрөмдлөг хийгдээгүй ба худаг өрөмдөх үеийн

болгоомжгүй үйл ажиллагаанаас гүний усанд машин техникийн шатах төсний материал болон бусад бохирдуулах бодис орох

3. Тухайн бүс нутагт үйл ажиллагааг түс Бетон зуурмагийн үйлдвэр нь явуулснаар гүний усыг тодорхой хэмжээнд ашиглах бөгөөд усны нөөцөд үйлдвэрлэлд хэдий хэр ус ашиглаж байна, төдий чинээгээр нөлөө үзүүлэх магадлалтай байна гэсэн үндсэн 3 сөрөг нөлөөлөл бий болж байгаа юм.

Мөн ахуйн хэрэглээнээс гарсан хаягдал усыг задгай, цементлэж хамгаалаагүй, энгийн нүхэн жорлон, муу усны нүхийг ашигласнаар тухайн бохир ус, хаягдал нь доош нэвчиж гүний усыг бохирдуулах магадлалтай гэж үзэж байна.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Үйлдвэрийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг 2024 онд батлагдсан Үйлдвэрийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан болон Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн №А/618 тушаалаар батлагдсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ын 1, 3 дугаар хавсралтын дагуу боловсрууллаа.

Энэхүү төлөвлөгөө нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулах явцад байгаль орчинд учрах сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, нөхөн сэргээх замаар байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа эрхлэхэд чиглэгдэнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

- Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгагдсан зөвлөмжүүдийг төлөвлөн хэрэгжүүлж, байгальд шууд болон шууд бус байдлаар үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, байгаль орчны төлөв байдлыг сайжруулах, хэвийн хадгалах, хамгаалах;
- Монгол Улсын Байгаль орчны багц хуулиудын хэрэгжилтийг хангах;
- Байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах талаар ажиллагсдад заавар, зааварчилгааг сургалтын хэлбэрээр олгох;
- Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх;
- Хог хаягдлын менежментийг сайжруулах;
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;
- Үйлдвэрийн үйл ажиллагааг орон нутгийн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад танилцуулж, тэдэнтэй санал бодлоо солилцох, нутгийн иргэдтэй хамтран ажиллах

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

5.1 Агаар орчныг хамгаалах чиглэлээр хийх ажлууд:

Зорилго: Үйлдвэрийн ажилчдын эрүүл аюулгүй орчинд ажиллах нөхцлийг бүрдүүлэх, хүрээлэн буй орчны тэнцлийг хадгалах зорилгоор орчны агаар дахь хими физикийн гаралтай түгээмэл бохирдуулагчийг стандарт хэмжээнээс хэтрүүлэхгүй байхад оршино.

Хүснэгт 5. Агаарт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Төслийн үйл ажиллагаанаас үүсэх тоос, тоосонцор	Орчны тоосжилтыг дарах зорилгоор усалгааг тогтмол хийж байх	Үйлдвэрийн хэмжээнд	-	100.000	-	100.000	Жилдээ, Тухай бүр	Агаарын тухай хууль, - MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага - Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2023, - Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага - MNS ISO 226:2003 дуу чимээ – хэвийн норм- түвшний хэмжээ
		Ажлын байрны орчны агаарын чанарыг сайжруулах зорилгоор агааржуулалтын систем болон тоосжилт бууруулах ус шүршигч төхөөрөмжийг бүрэн угсарч, тогтмол ажиллуулан агаарын цэвэршүүлэлтийг хангана.	Нийт ажилчид	-	1,250,000	1	1,250,000	Жилдээ	
		Үйлдвэрийн бүсэд агаарын чанарын хэмжилт хийх	Үйлдвэрийн бүсэд	ш	ОХШ хөтөлбөрт тусгагдсан	4	ОХШ хөтөлбөрт тусгагдсан	Улирал тутам	
	Нийт						1,350,000		

5.2 Газрын доорх усны нөөцийг хамгаалах чиглэлээр хийх ажлууд:

Зорилго: Үйлдвэрийн ажилчдын унд ахуйн усны нөөцөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад оршино.

Хүснэгт 6. Усан орчинд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Гадаргын усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл	Аюултай, хортой химийн бодисыг усан орчинд хаяхгүй байх, хяналт тавьж ажиллах.	Ашиглалтын гүний худаг	-	100,000	Тухай бүр	100,000	Жилдээ, Тухай бүр	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль, холбогдох дүрэм журам, бусад стандартууд
2		Ахуйн бохир ус, хатуу хаягдлаас урсац хөрсөнд алдагдахаас сэргийлэх, асгарсан тохиолдолд бохирдсон байдлаас шалтгаалан саармагжуулах, цэвэрлэх арга хэмжээ авах		-	Үйл ажиллагааны зардлаар	Тухай бүр	Үйл ажиллагааны зардлаар	Жилдээ, Тухай бүр	
3	Газар доорхи усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл	Технологийн усны хаягдалыг зориулалтын бохирын цооногт хадгалах		-	Үйл ажиллагааны зардлаар	Тухай бүр	Үйл ажиллагааны зардлаар	Жилдээ, Тухай бүр	Усны тухай хууль холбогдох дүрэм, журам, MNS 0900:2018
4		Гүний худгийн тоног төхөөрөмж, эрүүл ахуйн бүсийн хамгаалалтыг тогтмол шалгаж сайжруулалт хийх		-	100,000	Тухай бүр	100,000	Жилдээ, Тухай бүр	
5		Усны чанарын мониторинг хийх		ш	ОХШХ-т багтсан	Улирал тутам	ОХШХ-т багтсан	Улирал тутам	
	Нийт						200,000		

5.3 Хөрсөн бүрхэвчийг хамгаалах чиглэлээр хийх ажлууд:

Зорилго: Үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүссэн хөрсний элэгдэл эвдрэл, бохирдлыг багасгах байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах.

Хүснэгт 7. Хөрсөнд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хөрсний бохирдол үүсэх	Машин механизмд засвар үйлчилгээ хийх үед хөрс, ургамлыг шатах тослох материалаар бохирдуулахгүй байхад анхаарах, хяналт тавьж ажиллах	Үйлдвэрийн хэмжээнд	-	100,000-	-	100,000	Жилдээ, Тухай бүр	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, - MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
2	Газрын гадарга, хэвлий эвдэгдэх	Үйлдвэрийн талбайд олон салаа зам гаргахгүй байж, хяналт тавьж ажиллах.	Үйлдвэрийн хэмжээнд	-	Үйл ажиллагааны зардал	-	Үйл ажиллагааны зардал	Жилдээ	
3	Хөрсний бохирдол үүсэх	Хөрсний мониторинг хийх	Үйлдвэрийн хэмжээнд	удаа	ОХШ хөтөлбөрт багтсан	4	ОХШ хөтөлбөрт багтсан	Жилдээ, Тухай бүр	
4	Ногоон байгууламж, сул шороон гадаргаас тоосжилт үүсэх	Эвдрэлд орсон 2071 м² талбайг ногоон байгууламж болгон тохижуулна.	Үйлдвэртйн хашаалсан талбайд		Үйл ажиллагааны зардлаас	1	Үйл ажиллагааны зардлаас	5-6 сар	
	Нийт						100,000		

5.4 Ургамлан нөмрөг хамгаалах чиглэлээр хийх ажлууд:

Зорилго: Үйлдвэрийн бүсэд орчны ургамлын зүйлийн бүрдлийг нэмэгдүүлэх, амьтны аймгийг хамгаалах сөрөг нөлөөллийг бууруулахад оршино.

Хүснэгт 8. Ургамлан нөмрөгт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг арилгах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ургамлан нөмрөг талхлагдах	Хүн, техникийн чөлөөт зорчилтыг хязгаарлаж олон салаа зам гаргахгүй байх, маршрутын биш газраар машин техник нэвтрүүлэхгүй байх	Үйлдвэр орчмын бүс	ш	100,000	2	200,000	6-9 сар	БОННУ
2		Замын тэмдэг тэмдэглэгээ, болон бусад явган хүний явах хэсэг болон усны далан, овоолгийн хэсэгт тусгай тэмдэг тэмдэглэгээ хийх	Үйлдвэр орчмын бүс	ш	25,000	10	250,000	6-9 сар	БОННУ
	Нийт						450,000		

6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйлдвэрийн хэмжээнд 2025 онд нийт 2,071 м2 талбайд ногоон байгууламж, орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн ажлыг хийхээр төлөвлөв.

Хүснэгт 9. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Эвдрэлд орсон талбайг зүлэгжүүлэх	Зүдэг тарих	Үйлдвэрийн талбай	м ²	2071	Үйл ажиллагааны зардлаас		5-6 сар	Ургамал хамгаалах тухай хууль MNS 5917-2008; MNS 5918-2023 Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4
2	“Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ий хүрээнд мод тарих	Мод тарих	Үйлдвэрийн талбай	ш	70	10,000	700,000	Жилдээ, 5, 10 сард	
	Нийт						700,000		

7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбай болон түүний орчмын нутагт нь түүх соёлын дурсгалд тооцож болохуйц газар болон археологийн болон палеонтологийн олдвор одоогоор тохиолдоогүй.

Цаашид үйл ажиллагааны явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрсэн үед “Монгол Улсын Үндсэн хууль”-ийн I бүлгийн 7-р зүйлд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” гэж заасны дагуу түүх, соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулахтай холбоотой үүрэг хариуцлагаа мөрдөж ажиллана.

8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүдэн болзошгүй осол, саатал, химийн бодис асгаралт, техник, технологийн дуу чимээ болон галын гэнэтийн аюул үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. Үүнд:

8.1 Техник, технологийн аюулгүй байдлыг шалгах, хянах

- Тоног төхөөрөмж, дамжуулах шугам сүлжээний бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгах.
- Ашиглалтын горимыг чанд мөрдөж, хяналт тавих.

8.2 Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ

- Галын тусгай бүдүүвч схем боловсруулж батлах.
- Гал унтраах багаж хэрэгслээр ажлын байр бүрийг хангах.
- Гал түймрийн үед авах шуурхай арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх.

Хүснэгт 8. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Техник, технологийн аюулгүй байдлыг шалгах, хянах	Тоног төхөөрөмж, дамжуулах шугам сүлжээний бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгах.	Төслийн үйл ажиллагааны үед	-	200,000	200,000	Жилдээ, Тухай бүр	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон бусад хууль, холбогдох дүрэм журам, стандарт
2		Ашиглалтын горимыг чанд мөрдөж, хяналт тавих.	Төслийн үйл ажиллагааны үед	-				
3	Гал түймрээс урьдчилан сэргийлэх	Галын тусгай бүдүүвч схем боловсруулж батлах.	Нийт ажилтан	-	Үйл ажиллагааны зардал	Үйл ажиллагааны зардал	Жилдээ,	Галын аюулгүй байдлын тухай хууль холбогдох дүрэм журам, стандарт
4		Гал түймрийн үед авах шуурхай арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх.		-	Үйл ажиллагааны зардал	Үйл ажиллагааны зардал	Жилдээ,	
5		Гал түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, галын иж бүрэн багаж суурилуулах	Үйлдвэрийн хэмжээнд	-	500,000	500,000	Жилдээ,	
	Нийт					700,000		

9. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүссэн шингэн болон хуурай хог хаягдлын нөлөөгөөр байгаль орчин бохирдохоос урьдчилан сэргийлэх, ямар нэгэн байдлаар бохирдсон тохиолдолд тухайн сөрөг нөлөөллийг хурдан хугацаанд арилгахад оршино.

Хүснэгт 9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд дараах ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөв. Үүнд:

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн	3 тасалгаат хогийн савыг байрлуулах	Хог хаягдлын цэгт Лабортори болон төслийн гадна талбай	ш	200,000	2	400,000	Жилдээ	Хог хаягдлын тухай хууль Ариун цэврийн тухай хууль Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль,
		Ахуйн хог хаягдал цуглуулах цэгийн битүүмжлэл сайтай, агаар болон хөрс бохирдуулахааргүй болгон засаж сайжруулах		ш	800,000	1	800,000	Жилдээ	
		Хог хаягдлын менежментийг зохистой төлөвлөн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх	Үйлдвэрийн хэмжээнд	-	-	152.4	-	Жилдээ	
2	Аюултай	Аюултай хог хаягдлуудыг аюултай хог хаягдал тээвэрлэх, зайлуулах эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан тогтмол зайлуулж байх	Үйлдвэрийн хэмжээнд	-	Үйл ажиллагааны зардал	-	Үйл ажиллагааны зардал	Жилдээ	
	Нийт						1,200,000		

10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Зорилго: Хяналт шинжилгээний хөтөлбөрийг БОННУ-нд зөвлөмж болгосны дагуу тодорхойлсон хяналтын цэгүүд дээр, хуваарийн дагуу явуулж үйл ажиллагаанаас үүсэн гарах нөлөөллийг хянах, хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд байлгах явдал юм. Энэхүү орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн зардлыг гаргахдаа ЦУОШГ-н харьяа БОХЗЛ, Ханлаб ХХК-лабораторид мөрдөгдөж буй үнийг үндэслэн зардлын тооцсон.

Хүснэгт 10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
Хөрс								
1	Хүнд металлын шинжилгээ хийлгэх	Үйлдвэр орчим, хог хаягдлын цэг	6,9	Жилд 2 удаа 2 цэгт	36,000	144,000	Жилд 4 дээж	MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага
2	Хөрсний агро химийн үндсэн үзүүлэлтүүд		6,9	Жилд 4 удаа	59,600	238400	Жилд 4 дээж	
Ус								
3	Усны ерөнхий шинжилгээ хийлгэх	Унд ахуйн уснаас	6,9	Жилд 4 удаа	60,000	240,000	Жилд 4 дээж	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж
Агаар								
4	Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэх	Үйлдвэрийн талбайд	6,9	Жилд 2 удаа	36,000	72,000		MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
Нийт						694,400		

11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Үйлдвэрийн үйл ажиллагаа явуулах хугацаанд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалт, сурталчилгаа, мөрдөгдөх журам, төлөвлөгөөг цаг алдалгүй хийх тухайн ажлыг зөв зүйтэй зохион байгуулахад оршино. Үйлдвэрийн 7 хоногийн, сарын, улирлын төлөвлөгөөнд тухайн оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заагдсан ажлуудыг багтааж үр дүнг тухай бүрд нь компанийн болон төрийн байгууллагуудад тайлагнаж байх.

Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр дараах ажлуудыг хийнэ. Үүнд:

Хүснэгт 11. Удирдлага зохион байгуулалт

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв /төг/	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2025 он				
			Сар	Сар	Сар		
1	Байгаль орчныг хамгаалах талаар сургалт зохион байгуулах	100,000	-	8	-	Байгаль орчны мэргэжилтэн	Жилд 1 удаа
2	Цахилгааны сүлжээний бүрэн бүтэн байдалд мэргэжлийн байгууллагаар үзлэг хийлгэж, дүгнэлт гаргуулах	300,000	-	10	-	Байгаль орчны мэргэжилтэн	2 жил тутамд
3	Байгаль орчныг хамгаалах талаар сурталчилгаа анхааруулгын самбар, хуудас гаргах	200,000		7		Байгаль орчны мэргэжилтэн	Жилд 1 удаа
	Нийт	600,000					

12. ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ-НИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Үйл ажиллагаа явуулж байх хугацаандаа орон нутгийн иргэд болон төрийн байгууллагыг үнэн зөв бодит мэдээллээр хангахад оршино.

Хүснэгт 12. нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	СХДүүргийн 20 хорооны ИНХурлын дарга, төлөөлөгчид, Засаг дарга, холбогдох бусад байгууллага болон нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчид	Хурал зохион байгуулах	Тухайн жилийн БОМТ түүний хэрэгжилт	10 сард	250,000.0	Үйлдвэрийн дарга Байгаль орчны мэргэжилтэн	Үйлдвэрийн захиргаа
	Нийт				250,000.0		

13. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ АЖЛЫН ЗАРДЛЫН УРЬДЧИЛСАН ЗАДАРГАА

Тухайн жил байгаль орчныг хамгаалах ажилд 4,850,000 төгрөг, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 694,400 төгрөг, орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний хүрээнд зарцуулахаар 700,000 төсөвлөв. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нийтдээ 6,244,400 төгрөг зарцуулна.

Хүснэгт 16. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний урьдчилсан зардал

Дд	Хийгдэх ажлууд	Зардал, төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	2,100,000
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний хүрээнд зарцуулах	700,000
3	Түүх соёлын өвийг хамгаалах зардал	-
4	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөөний хүрээнд зарцуулах зардал	700,000
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүрээнд зарцуулах зардал	1,200,000
6	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	600,000
7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	694,400
8	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад болон орон нутагт тайлагнахад гарах зардал	250,000.
9	Нийт	6,244,400